

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
	2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
	2.12. Шилэн дансны мэдээлэл	10
	2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
	2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
	4.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан.....	14
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан	16
	4.5 Батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан	17
5	Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН
САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТБАЯР ТАНАА

2020.03.13 № 06/841
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй дүгнэлт

Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Сангийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн 8 дугаар зүйл болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Б.Батбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, сангийн үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилтийг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Зээлийн батлан даалтын сангийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор С.Цэнгэлмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны санхүүгийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 1/93 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Зээлийн батлан даалтын сангийн зорилго нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сангийн үйл ажиллагааг оновчтой, үр ашигтай явуулахад чиглэгдэнэ.

Зээлийн батлан даалтын сан 2019 онд батлан даалтын 320 хүсэлт хүлээн авч, түүнээс 89.1 хувь буюу 285 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд 47,892.2 сая төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг дараах ангиллаар төвлөрүүлэхээр зорилт тавьсан байна. Үүнд:

1. Үйлчилгээний хураамж 10.8 сая төгрөг
2. Батлан даалтын шимтгэл 727.2 сая төгрөг

2019 онд батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн 116 харилцагчдын 111 буюу 95.6 хувьд нь 20.5 тэрбум төгрөгийн батлан даалттай, 37.7 тэрбум төгрөгийн зээл олгогджээ.

Тайлант хугацаанд олгосон батлан даалтын дүнг 2018 оны мөн үетэй харьцуулахад зээлдэгчийн тоо 43.2 хувиар, батлан даалтын хэмжээ 41.9 хувиар тус тус буурсан байна. 2019 онд гаргасан батлан даалтын 86 хувь нь Улаанбаатарт, 14 хувь нь орон нутагт, 44.8 хувь нь үйлчилгээ, 26.5 хувь нь үйлдвэрлэлийн салбарт олгогдож, 496 ажлын байр шинээр нэмэгдсэн байна.

Зээлийн батлан даалтын сангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дөрвөн заалтад зохистой харьцааг тооцох шалгуур үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулсан байна.
- Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах байршуулах журам”-д өөрчлөлт оруулж, найдваргүй авлагын санг байгуулах заалтын хэрэгжих хугацааг хойшлуулсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Зээлийн батлан даалтын сангийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг байгууллагын санхүүгийн ажилтнууд өөрсдөө шинээр боловсруулж, Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжид бүрэн нийцээгүй, сайжруулах шаардлагатай байна.

Зээлийн батлан даалтын сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Даймонд 5.0 программ хангамж ашигладаг байна.

Зээлийн батлан даалтын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Зээлийн батлан даалтын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр эхний хагас жилийн байдлаарх нийт хөрөнгийг сонгож, эрсдлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг хамгийн бага буюу 0.2 хувиар тогтоов. Урт хугацаат зээлийн дүн нийт хөрөнгийн 82.9 хувийг эзэлж байгаа, нийт гүйлгээний 90 орчим хувь нь бага дүнтэй гүйлгээ байгаа тул хамгийн бага хувийг сонгосон.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 72,278.2 сая төгрөгөөс тооцон **144.6** сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг **145.2** сая төгрөгөөр тооцсон нь жилийн эцсийн байдлаарх нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,970.1 сая төгрөгөөр буюу 43.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, хязгаарлалттай нөөц болон цэвэр хөрөнгийн бусад хэсэг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	41,650.6	61,089.8	19,439.20
Авлага	526.6	11,230.0	10,703.4
Урьдчилж төлсөн зардал	2.8	2,865.1	2,862.3
Бараа материал	21.4	31.7	10.3
Үндсэн хөрөнгө	201.6	167.4	(34.2)
Биет бус хөрөнгө	91.3	80.4	(10.9)
Нийт хөрөнгө	42,494.3	75,464.4	32,970.1
Богино хугацаат өр төлбөр	329.7	1,210.3	880.6
Урт хугацаат өр төлбөр	32,760.4	62,818.9	30,058.5
Хязгаарлалттай нөөц хөрөнгө	5,922.0	7,800.0	1,878.0
Цэвэр өмчийн бусад хэсэг	2,007.7	2,911.8	904.1
Хуримтлагдсан үр дүн	1,474.5	723.4	(751.1)
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	42,494.3	75,464.4	32,970.1

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь Азийн хөгжлийн банкны төслийн зээлийн санхүүжилтээс батлан даалт гаргаж банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл нэмэгдсэн нь тайлант онд бусад авлага дансанд Азийн хөгжлийн банкны төслийн зээлийн санхүүжилтээр хийсэн батлан даалт 10,130.9 сая төгрөгөөр, мөн чанаргүй батлан даалтын үүрэг гүйцэтгэл 747.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл өссөн нь Сангийн яам, Зээлийн батлан даалтын сангийн хооронд 2016 онд байгуулсан 170/32 тоот дамжуулан зээлдүүлэх гэрээний 3.1.3 заалтын дагуу 2019 онд төлөхөөр тооцоолон бүртгэсэн 2,249.3 сая төгрөгийн зээлийн хүү, ашиглаагүй зээлийн үлдэгдэлд төлөх амлалтын шимтгэлийг Сангийн яамтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, АХБ болон Засгийн газар хоорондын зээлийн гэрээний 4.18 заалтын дагуу хуримтлуулан бүртгэсэн нь нөлөөлсөн байна. Мөн дамжуулан зээлдэх гэрээний 3.1.2 заалтын дагуу 2017-2019 оны шимтгэлийн зардлыг 612.9 сая төгрөгөөр илүү төлснийг тайлагнасан байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүн өссөн нь шүүхийн шийдвэр гарсан батлан даалтад 747.9 сая төгрөгийн үүрэг гүйцэтгэж, Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2018 оны 22 дугаар тушаалаар батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах байршуулах журам”-ын 3.3.3 заалтын дагуу нөөц санг нөхөн бүрдүүлэхээр өглөг үүсгэн тайлагнасанаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөрийн дүн нэмэгдсэн нь Сангийн яамтай хийсэн дамжуулан зээлдэх гэрээний дагуу банкуудад хадгаламжаар байршуулсан Азийн хөгжлийн банкны төслийн зээлийн хөрөнгийн санхүүжилт, хүлээн авсан зээлийн хүүгийн зардал, ашиглаагүй зээлийн үлдэгдэлд тооцох амлалтын шимтгэлийн зардлыг хуримтлуулан бүртгэж, тайлагнаснаас шалтгаалжээ.

Хязгаарлалттай нөөц хөрөнгийн дүнг ЗБДС-ийн УЗ-ийн 2019 оны 10 дугаар тогтоолоор 1,078.0 сая төгрөг, 2019 оны 16 дугаар тогтоолоор 800.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх шийдвэр гаргаж өөрийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нэмэгдүүлсэн байна.

Цэвэр хөрөнгийн бусад хэсэг дансны үлдэгдэл 904.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны тайлангийн цэвэр ашгийн дүнгээс 51 хувиар нөөц санг нэмэгдүүлж, батлан даалтын үүрэг гүйцэтгэсэн дүнгээр нөөц санг хасагдуулан тайлагнасан нь шалтгаалжээ.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор 2019 оны үйл ажиллагааны төсвийг баталсан байна. Тайлант онд 5,228.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,056.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 96.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Орлогын гүйцэтгэл

	/сая төгрөг/			
Санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хүүний орлого	4,490.7	4,531.7	41.0	100.9
Батлан даалтын хураамж, шимтгэлийн орлого	738.0	524.7	(213.3)	71.1
Нийт дүн	5,228.7	5,056.4	(172.3)	96.7

Батлан даалтын хураамж, шимтгэлийн орлого 28.9 хувиар тасарсан нь өмнөх оноос батлан даалтын хэмжээ 41.9 хувиар буурсанаас шалтгаалсан байна.

Удирдах зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 11 тоот тогтоолоор 65.1 сая төгрөгөөр зардлыг нэмэгдүүлэн, 1,586.6 сая төгрөг зарцуулахаар тодотгосон байна.

Тайлант онд ерөнхий ба удирдлагын зардалд 1,575.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулахаар баталсан нь өмнөх оны зардлын гүйцэтгэлээс 392.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь ажилтнуудын үндсэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 15 хувиар, түрээсийн зардал, албан томилолт, засвар үйлчилгээ, бусад зардлуудыг нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Батлагдсан төсвөөс үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 1,303.5 сая төгрөг буюу 82.7 хувьтай байгаа нь цалинтай холбоотой зардал 209.8 сая төгрөг, түрээсийн зардал 21.8 сая төгрөг, хангамжийн зардал 22.3 сая төгрөг, албан томилолтын зардал 6.5 сая төгрөг, бусад зардал 13.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Төслийн үйл ажиллагаатай холбоотой чанаргүй батлан даалтын үүрэг гүйцэтгэсэн 747.9 сая төгрөг, дамжуулан зээлдүүлэх гэрээний шимтгэлийн 1,280.5 сая төгрөгийн төсөв батлагдаагүй зардлууд гарсан байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж, нийт 23 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3,529.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,529.8 сая төгрөгийн алдааг залруулж, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, сангийн үйл ажиллагаанд мөрдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулан алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 асуудлаар зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 3 асуудлаар нийт 3,529.8 сая төгрөгийн алдааг залруулан тайлагнасан. Үүнд:

1. Сангийн яамтай 2016 онд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний 3.1.3 заалтын дагуу 2019 оны хүүгийн зардал, амлалтын шимтгэл 2,249.3 сая төгрөгийн өглөгийг Азийн хөгжлийн банкны системийн мэдээтэй тулган хуримтлуулан бүртгээгүй,
2. Дээрх дамжуулан зээлдүүлэх гэрээний 3.1.2 заалтын дагуу Сангийн яаманд төлсөн шимтгэлийг аккруэл сууриар бүртгээгүй 1,020.6 сая төгрөгийг зардлаар илүү тайлагнасан,
3. Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан журамд нийцүүлэн тайлагнаагүй байна. Үр дүнгийн тайланг өмнөх оны үзүүлэлттэй зэрэгцүүлэн

тайлагнаагүй, Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан болон санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгийн бүлгийг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн загвараар тайлагнасан байна.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэхээр хуваарилагдсан цаг хугацааны хязгаарлагдмал байдал, өвчний улмаас хорио тогтоосон нөхцөл байдлаас үйлчлүүлэгчийн байранд ажиллах боломжгүй байсан тул батлан даалтын үйл ажиллагаа, хураамж шимтгэлийн орлогыг нарийвчлан шалгаагүй болно. Гэвч Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит шалгалт, Удирдах зөвлөлийн дэргэдэх хяналтын зөвлөлийн шалгалтад дээрх үйл ажиллагааг хамруулсан байгаа тул шалгалтын материалыг аудитад ашигласан болно.

Дараагийн аудитаар батлан даалтын үйл ажиллагаа, чанаргүй батлан даалтын эрсдлээс сэргийлэх найдваргүй авлагын нөөц сангийн бүртгэл, үндсэн үйл ажиллагааны орлогыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Зээлийн батлан даалтын сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 152 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5 алдаа зөрчил илрүүлж, үүнээс 1 асуудлаар албан шаардлага, 4 асуудлаар зөвлөмж өгснөөс 100 хувь буюу бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт:

Зээлийн батлан даалтын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурьдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн ажилтнууд боловсруулан Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөж байна. Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөц сан, найдваргүй авлагын нөөц, зээлийн хүүгийн болон амлалтын шимтгэлийн зардлууд, хадгаламжийн болон харилцах дансдын үлдэгдлийн хүүгийн орлого, батлан даалтын хураамж шимтгэлийн орлогуудыг аккрузал сууриар тооцоолон бүртгэх зэрэг нягтлан бодох бүртгэлийн горимууд, зарим дансдын ангиллуудыг зөв тодорхойлоогүй байна.

3.1.2 Эрсдэл: Тайлангийн толилуулга ба тодруулга, үнэн ба зөв, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн горим боловсруулахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хууль, стандарт, дүрэм, журам, байгууллагын онцлог үйл ажиллагааг тодорхойлж СЗХ-ны 2019 оны 46 дугаар тогтоолоор баталсан “ЗБДС-ийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, ЗБДС-ийн удирдах зөвлөлийн 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “ЗБДС-ийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах байршуулах журам”-д нийцүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч сайжруулан мөрдөнө.

3.2 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчны асуудал

3.2.1 Илрүүлэлт 2019 оны жилийн эцсийн тайланд нийт гаргасан батлан даалтын 15.4 хувь нь чанаргүй, 2.6 хувь нь хугацаа хэтэрсэн үзүүлэлттэй тайлагнасан байна. Удирдах зөвлөлийн 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах байршуулах журам”-ын 3.4 дэх заалтын дагуу найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна.

3.2.2 Эрсдэл Удирдах зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор “Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журам”-ын найдваргүй авлагын нөөц сан байгуулахтай холбоотой заалтыг хэрэгжүүлэхийг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан нь үүсэх эрсдлээс чөлөөлөгдөхгүй

3.2.3 Өгсөн зөвлөмж Чанаргүй батлан даалтын эрсдлээс ирээдүйд үүсэх болзошгүй үүрэг гүйцэтгэлийг зөв тооцоолон холбогдох журмын найдваргүй авлагын нөөц сан байгуулах заалтыг тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр өөрчлөх, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх хууль тогтоомжийг тогтвортой мөрдөх, цаашид дээд шатны байгууллагуудын хяналт шалгалтын зөвлөмжийг биелүүлж, алдааг давтан гаргахгүй байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар Зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	41,650,621,842.03	61,089,802,392.20
1.1.2	Дансны авлага	12,286,937.58	-
1.1.3	Бусад авлага	514,297,485.14	11,229,928,657.86
1.1.4	Бараа материал	21,403,037.00	31,747,130.00
1.1.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,775,000.00	2,865,068,636.42
1.1.6	Эргэлтийн хөрөнгийн дүн	42,201,384,301.75	75,216,546,816.48
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	386,168,379.90	383,799,179.90
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл	(184,524,388.26)	(216,369,672.03)
1.2.3	Биет бус хөрөнгө	124,237,900.00	124,237,900.00
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл	(32,897,360.62)	(43,788,405.82)
1.2.5	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	292,984,531.02	247,879,002.05
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	42,494,368,832.77	75,464,425,818.53
2	ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	324,128,800.80	1,024,293,351.73
2.1.1.2	Цалингийн өглөг	103,165.00	-
2.1.1.3	Татварын өглөг	5,300,763.69	-
2.1.1.4	Богино хугацаат зээл	-	78,907.00
2.1.1.5	Хүүгийн өглөг	500.00	500.00
2.1.1.6	Урьдчилж орсон орлого	-	185,973,926.43
2.1.1.7	Нөөц /өр төлбөр/	141,974.00	-
2.1.1.8	Богино хугацаат өр төлбөрийн дүн	329,675,203.49	1,210,346,685.16
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	32,470,419,543.19	62,528,872,504.80
2.1.2.2	Бусал урт хугацаат өр төлбөр	290,000,000.00	290,000,000.00
2.1.2.3	Урт хугацаат өр төлбөрийн дүн	32,760,419,543.19	62,818,872,504.80
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	33,090,094,746.68	64,029,219,189.96
2.3	Цэвэр хөрөнгө		
2.3.1	Нөөц: а) Хязгаарлалтгүй		
2.3.2	б) Хязгаарлалттай	5,922,000,000.00	7,800,000,000.00
2.3.3	Цэвэр хөрөнгийн бусад хэсэг	2,007,684,371.72	2,911,807,884.23
2.3.4	Хуримтлагдсан үр дүн	1,474,589,714.37	723,398,744.34
2.3.5	Цэвэр хөрөнгийн дүн	9,404,274,086.09	11,435,206,628.57
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН	42,494,368,832.77	75,464,425,818.53

4.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны орлого		
2	Хүүгийн орлого	3,255,242,747.35	4,531,678,983.99
3	Батлан даалтын хураамж, шимтгэлийн орлого	542,503,084.63	339,406,510.55
4	Үйл ажиллагааны орлогын нийт дүн	3,797,745,831.98	4,871,085,494.54
5	Үндсэн үйл ажиллагааны зардал		
6	Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	765,825,512.24	259,996,854.24
7	Төсөл хэрэгжүүлсний зардал	2,259,558.00	4,595,779.00
8	Ерөнхий удирдлагын зардал		
9	Цалин хөлс, шагнал	648,140,756.00	820,771,253.00
10	Нийгмийн даатгалын шимтгэл	82,377,150.00	103,742,977.96
11	Засвар үйлчилгээний зардал	17,090,776.67	22,209,475.00
12	Ашиглалтын зардал		1,028,986.00
13	Түрээсийн зардал	127,432,000.00	177,010,108.00
14	Албан томилолтын зардал	55,952,077.00	61,266,651.40
15	Элэгдлийн зардал	45,424,749.36	54,713,531.56
16	Зар сурталчилгааны зардал	26,494,591.00	26,254,496.33
17	Шуудан, холбооны зардал	9,035,114.54	6,652,073.77
18	Шатахууны зардал	33,404,884.40	31,994,556.30
19	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	52,917,058.00	36,077,544.00
20	Бусад зардал	77,041,223.76	119,041,841.08
21	Үйл ажиллагааны зардлын дүн	1,943,395,450.97	1,725,356,127.64
22	Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал	1,854,350,381.01	3,145,729,366.90
23	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдал		
24	Вальютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал)	27,524,035.98	
25	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		66,497.41
26	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдлын дүн	27,524,035.98	66,497.41
27	Тайлант үеийн цэвэр үр дүн	1,826,826,345.03	3,145,662,869.49

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,466,213,952.04	3,044,833,812.83
	Гишүүдийн татвараас орсон мөнгө		524,724,436.98
	Түрээсийн орлогод хүлээн авсан мөнгө		
	Бусад орлого	3,466,213,952.04	2,520,109,375.85
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,261,779,273.73	3,992,392,266.15
	Ажилчдад төлсөн	535,245,421.00	660,760,089.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	150,942,762.68	192,715,411.28
	Бараа материал худалдан авахад төлсөн	21,563,863.12	17,641,409.94
	Ашиглалтын зардалд төлсөн	127,432,000.00	178,039,094.00
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	42,135,780.50	31,994,556.30
	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	107,856,230.15	115,015,892.54
	Төлсөн хүү		145,286,594.35
	Татварын байгууллагад төлсөн	83,453,857.51	69,234,709.69
	Бусад	4,193,149,358.77	2,581,704,509.05
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,795,565,321.69)	(947,558,453.32)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	(107,919,700.00)	(9,674,500.00)
	Бусад	10,000,000.00	-
2.2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(97,919,700.00)	(9,674,500.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Банкнаас авсан зээл	16,380,822,474.90	17,712,811,560.95
	Улсаас өгсөн санхүүжилт	300,000,000.00	
	Хүү ба урамшууллын орлого	4,388,656,589.26	4,531,678,983.99
	Вальютын ханшийн зөрүү	(171,422,623.00)	(747,953,130.93)
	Дамжуулан зээлийн шимтгэлийн төлбөр		(1,280,546,354.40)
	Бусад		180,422,443.88
3.2	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,898,056,441.16	20,396,413,503.49
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	19,004,571,419.47	19,439,180,550.17
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,646,050,422.56	41,650,621,842.03
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,650,621,842.03	61,089,802,392.20

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Хязгаарлалттай нөөц	Цэвэр хөрөнгийн бусад хэсэг	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,040,000,000.00	1,249,299,822.20	1,152,597,841.86	7,441,897,664.06
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл	5,040,000,000.00	1,249,299,822.20	1,152,597,841.86	7,441,897,664.06
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт				-
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	882,000,000.00	758,384,549.52	(1,504,834,472.52)	135,550,077.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	1,826,826,345.03	1,826,826,345.03
8	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,922,000,000.00	2,007,684,371.72	1,474,589,714.37	9,404,274,086.09
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(414,565,776.08)	(414,565,776.08)
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,922,000,000.00	2,007,684,371.72	1,060,023,938.29	8,989,708,310.01
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт				-
12	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	1,878,000,000.00	904,123,512.51	(3,482,288,063.44)	(700,164,550.93)
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
14	Тайлант үеийн үр дүн			3,145,662,869.49	3,145,662,869.49
15	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,800,000,000.00	2,911,807,884.23	723,398,744.34	11,435,206,628.57

4.5 Батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,585,578,227.40	3,330,034,431.75	(1,744,456,204.35)	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,585,578,227.40	3,330,034,431.75	(1,744,456,204.35)	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,526,508,247.40	1,339,649,026.42	186,859,220.98	87.76%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,869,044.00	660,760,089.00	16,108,955.00	97.62%
210101	Үндсэн цалин	676,869,044.00	660,760,089.00	16,108,955.00	97.62%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,000,000.00	192,715,411.28	284,588.72	99.85%
210201	Тэтгэврийн даатгал	193,000,000.00	192,715,411.28	284,588.72	99.85%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,800,000.00	178,039,094.00	21,760,906.00	89.11%
210301	Гэрэл цахилгаан	2,400,000.00	1,028,986.00	1,371,014.00	42.87%
210304	Байрны түрээс	197,400,000.00	177,010,108.00	20,389,892.00	89.67%
2104	Хангамж, бараа материалын зардал	78,563,847.50	56,288,040.01	22,275,807.49	71.65%
210401	Бичиг хэрэг	17,061,310.00	9,736,399.94	7,324,910.06	57.07%
210402	Тээвэр, шатахуун	42,483,537.50	31,994,556.30	10,488,981.20	75.31%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,021,000.00	6,652,073.77	2,368,926.23	73.74%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,998,000.00	7,905,010.00	2,092,990.00	79.07%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,517,000.00	22,209,475.00	11,307,525.00	66.26%
210604	Урсгал засвар	33,517,000.00	22,209,475.00	11,307,525.00	66.26%
2107	Томилолт, зочны зардал	80,768,450.00	74,242,662.36	6,525,787.64	91.92%
210701	Гадаад албан томилолт	-	-	-	-
210702	Дотоод албан томилолт	75,768,450.00	69,646,883.36	6,121,566.64	91.92%
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	4,595,779.00	404,221.00	91.92%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,393,899.90	108,363,818.77	18,030,081.13	85.74%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,200,000.00	82,109,322.44	9,090,677.56	90.03%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	35,193,899.90	26,254,496.33	8,939,403.57	74.60%
2109	Бараа үйлчилгээний буад зардал	13,330,000.00	10,952,892.00	2,377,108.00	82.17%
210901	Бараа үйлчилгээний буад зардал	-	-	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,330,000.00	10,952,892.00	2,377,108.00	82.17%
211	ХҮҮ	-	1,280,546,354.40	(1,280,546,354.40)	
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,280,546,354.40	(1,280,546,354.40)	
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,280,546,354.40	(1,280,546,354.40)	
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,270,000.00	36,077,544.00	13,192,456.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,270,000.00	36,077,544.00	13,192,456.00	73.22%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,799,980.00	9,674,500.00	125,480.00	98.72%
222001	Тоног төхөөрөмж	9,799,980.00	9,674,500.00	125,480.00	98.72%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	700,164,550.93	(700,164,550.93)	
230001	Эргэж төлөгдөх зээл	-	700,164,550.93	(700,164,550.93)	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,228,756,986.30	22,769,214,981.92	(17,540,457,995.62)	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,228,756,986.30	22,769,214,981.92	(17,540,457,995.62)	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	738,000,000.00	524,724,436.98	213,275,563.02	71.10%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,490,756,986.30	4,531,678,983.99	(40,921,997.69)	100.91%
350004	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-	17,712,811,560.95	(17,712,811,560.95)	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	41,650,621,842.03	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	61,089,802,392.20	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	
610002	Төсвөөс гадуур байгууллага	1.00	1.00	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	72.00	72.00	-	
620001	Удирдах ажилтан	17.00	17.00	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	-	
620004	Гэрээт ажилтан	23.00	23.00	-	

5 Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын н нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/91/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Зээлийн батлан даалтын сан			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	3	4	5	8	9
1	2019 оны жилийн эцсийн тайланд нийт гаргасан батлан даалтын 15.4 хувь нь чанаргүй, 2.6 нь хугацаа хэтэрсэн үзүүлэлттэй тайлагнасан байна. Найдваргүй авлагын нөөц байгуулж, бүртгээгүй.	Үйл ажиллагаа	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан	Б.Батбаяр Б.Уранбилэг
2	НББ-ийн бодлогын бичиг баримт боловсруулан баталсан боловч нягтлан бодох бүртгэлийн горимуудыг сангийн үйл ажиллагааны холбогдох хууль, дүрэм, журамд бүрэн нийцээгүй байна.	Үйл ажиллагаа	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан	Б.Батбаяр Б.Уранбилэг
Нийт дүн		-			

ТЭМДЭГЛЭЛ

A series of 25 horizontal dotted lines for writing a conclusion.

